



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/371

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх үзлэг,
шинжилгээг зохион байгуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны 10 тоот тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх зорилтын хүрээнд Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал суманд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээг зохион байгуулахад 9,881,260 (есөн сая найман зуун наян нэгэн мянга хоёр зуун жаран) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Доржханд)-д, зорилтот насны хүн амыг бүрэн хамруулж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх үзлэгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 06-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Нийт төсөв: 9.881.260
Томилолт: 2.451.500
Урвалж, оношлуурын зардал: 6.866.000
Шатахууны зардал: 563,760
Шатахууны зардал:

№	Сумдын нэрс	Ажиллах хоног	Туулах зам км
1	Чингис- Дэлгэрхаан	3	145
2	Дэлгэрхаан – Цэнхэрмандал	2	90
3	Цэнхэрмандал -Жаргалтхаан	2	80
4	Жаргалтхаан-Чингис	1	100
5	Сум доторх		20
	Нийт	8	435 /563,760/

Шатахууны зардал: /1 литр 3600, 100км-т 20 литр дезиль түлш хэрэглэхээр 1 машинаар тооцов/. Нийт-2 машин/

Томилолтын зардал:

Д/д	Нэрс	Ажиллах хоног	Өдрийн томилолт	Нийт
1	Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн	5	49030	245150
2	Сүрьеэгийн их эмч	5	49030	245150
3	Дүрс оношлогооны их эмч	5	49030	245150
4	БЗДХ/ДОХ-ын их эмч	5	49030	245150
5	Дотрын их эмч	5	49030	245150
6	Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч	5	49030	245150
7	Рентген техникч	5	49030	245150
8	Лаборант	5	49030	245150
9	Жолооч	5	49030	245150
10	Жолооч	5	49030	245150
	Дүн			2.451.500

Урвалж оношлуур:

Д/д	Оношлуурын нэр	Хүний тоо	Оношлуурын үнэ багцаар	Бүгд үнэ
1	Тэмбүүгийн тест	300 ш	1 ш*3500	1,050,000
2	ДОХ-ын оношлуур	300 хүн тун	1 х/тун *3500	1,050,000
3	С вирус	300ш	1ш*4000	1.200.000
4	В вирус	300ш	1ш*4000	1.200.000
5	Сахарын тест	300ш	50х/т*36000	216,000
6	Хеликобактерын тест	300ш	1ш*3800	1.140.000
7	Бээлий	500 хос	500*700	350,000
8	Үзлэгийн толь	300ш	300*2200	660.000
	Нийт дүн			6.866.000